



Хууль эрх зүйн мэдээлэл

Дугаар 2/25



Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлагатай холбоотой анхаарах асуудлууд

Бэлтгэсэн:

- Б.Амарбат, Хуулийн үйлчилгээний менежер, LL.M
- Ч.Номин-Эрдэнэ, Хуулийн зөвлөх

2025 оны 2-р сар

Энэ удаагийн хууль эрх зүйн мэдээллээр бид 2023 оны 9 сарын 11-ны өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас баталсан Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам, түүнтэй холбоотой анхаарах асуудлуудыг (“Хүний эмзэг мэдээллийн журам” эсвэл “Журам”) онцолж байна.

ТОВЧООР

2021 онд Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (“ХХМХтХ”) батлагдсанаар тус харилцаанд олон дэвшилтэт, шинэ хууль, эрх зүйн ойлголтууд бий болж байсан. Тус хуулиар хүний хувийн мэдээллийг төрлөөс нь хамаарч эмзэг, нууц, биометрик болон генетик мэдээлэл зэргээр ангилсан байдаг. Цаашлаад ийм төрлийн мэдээллийн хэрэглээг хязгаарлах, мэдээлэл хариуцагч энэ төрлийн мэдээлэл цуглуулах, ашиглах, боловсруулах тохиолдолд хуулийн илүү нарийвчилсан шаардлагуудыг дагаж мөрдөхөөр зохицуулжээ.

ХХМХтХ-ийг дагалдаж Хүний эмзэг мэдээллийн журам батлагдсан бөгөөд тус журмаар хүний эмзэг, биометрик болон генетикийн мэдээллийг боловсруулахад баримтлах зарчим, технологийн аюулгүй байдал болоод мэдээлэл боловсруулах серверт тавигдах шаардлага зэргийг нарийвчлан зохицуулсан байдгийг энэ удаагийн Хуулийн мэдээллээрээ онцлон авч үзлээ.

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ: ЭМЗЭГ, БИОМЕТРИК БОЛОН ГЕНЕТИК МЭДЭЭЛЭЛ ГЭЖ ЯМАР МЭДЭЭЛЛҮҮДИЙГ ХЭЛЭХ ВЭ?



PwC Legal
A multidisciplinary law firm

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд дурдсан тухайн асуудал бүрээр олон талын цогц дүн шинжилгээг агуулаагүй болно. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2025 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү баримт бичигт дурдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.

ХҮНИЙ ЭМЗЭГ МЭДЭЭЛЭЛ АШИГЛАХ ҮНДЭСЛЭЛҮҮД

1

Хуульд тусгайлан заасан
үндэслэлээр

2

Хуульд заасан шаардлагуудыг хангаж
мэдээллийн эзнээс зөвшөөрөл авснаар

ХҮНИЙ ЭМЗЭГ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХАД ТАВИГДАХ ЗАРЧИМ

Хүний эмзэг мэдээллийн журамд хүний эмзэг мэдээллийг боловсруулах үйл ажиллагаанд дараах зарчмуудыг дагаж мөрдөхөөр заасан бөгөөд энэ нь Европын холбооны Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай ерөнхий хуульд (GDPR, 2016) тусгасан зарим зарчмуудтай нийцэж байгаа юм.

Ил тод байх	Мэдээллийн эзэнд түүний аль мэдээллийг, ямар зорилгоор хэрхэн ашиглах талаар ил тод, тодорхой, ойлгомжтой мэдэгдэх
Зорилгодоо нийцсэн байх	Мэдээллийг зөвхөн зориулагдсан зорилгын хүрээнд ашиглах, мэдээллийг бусад зорилгоор ашиглахгүй байх
Хадгалалтын хязгаарлалттай байх	Шаардлагагүй болсон хувийн мэдээллийг хадгалалгүйгээр устгаж байх
Хариуцлагатай байх	Хууль, журмын шаардлагуудыг дагаж мөрдөх
Эрсдэлийн үнэлгээнд тулгуурласан байх	Хууль, журамд заасны дагуу эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, түүнд суурилсан арга хэмжээ авч хэрэгжүүлдэг байх.
Мэдээллийн нэгдсэн системтэй байх	Хүний эмзэг мэдээллийг боловсруулах аюулгүй нэгдсэн системтэй байх

ХҮНИЙ ЭМЗЭГ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ТЕХНОЛОГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хүний эмзэг мэдээллийг боловсруулах технологи гэдэгт хүний эмзэг мэдээллийг цуглуулах, түүнд ямарваа нэг байдлаар боловсруулалт хийх үед хэрэглэгдэж буй бүхий л төрлийн програм хангамж, сервер болон бусад технологийн шийдлүүдийг ойлгодог. Үүнтэй холбогдуулан хүний эмзэг мэдээллийг аливаа технологи ашиглан боловсруулж буй этгээдүүдэд дараах нийтлэг үүргийг хүлээхээр Журамд зохицуулжээ. Үүнд:



Мэдээллийн аюулгүй байдлыг хангах дотоод журам баталж мөрдөх



Мэдээллийн аюулгүй байдлын ажилтан / нэгж томилох



Мэдээлэл боловсруулах программ, сүлжээ, төхөөрөмж нь эрх бүхий этгээдээс зөвшөөрөгдсөн байх



албан ёсны лицензтэй программ хангамж ашиглах, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хоёр жил тутамд эсхүл шаардлагатай тохиолдолд тухай бүр хийлгэх



мэдээлэл аюулгүй байдлын аудитыг жил тутамд эсхүл аюулгүй байдал алдагдсан тохиолдол бүрд хийлгэх;



Мэдээлэл хариуцагч нь мэдээллийг өөрчилсөн, устгасан, сэргээсэн тухай түүхчилсэн бүртгэлийг хөтөлж, хяналт тавин мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан байдлыг хангах

ХҮНИЙ ЭМЗЭГ МЭДЭЭЛЭЛ БОЛОВСРУУЛАХ СЕРВЕРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

Харин хүний эмзэг мэдээллийг аливаа сервер ашиглан боловсруулж буй тохиолдолд тухайн серверт дараах нийтлэг шаардлага тавигдахаар Журамд заасан байна. Үүнд:

Сервер нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байршдаг байх

зөвхөн Монгол Улсаас нэвтрэх /хандах/ боломжтой байх

зориулалтын техникийн өрөөнд серверийг байршуулсан байх

шаардлагатай тохиолдолд серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжтой байх

харилцаа холбооны зохицуулах хорооны сүлжээний цагийн сервертэй холбогдсон байх

төрийн мэдээлэл солилцооны "ХҮР" системээр дамжуулан мэдээлэл солилцох боломжтой байх

мэдээлэл солилцох системийг "SSL" сертификатаар хамгаалсан байх

тогтмол хугацаанд мэдээллийн системийг нөөцөлдөг байх

Хүний эмзэг мэдээлэл боловсруулах сервер гадаад улсад байрших боломжтой эсэх?

Дээр харуулсанчлан Журамд хүний эмзэг мэдээлэл боловсруулах сервер нь Монгол улсын нутаг дэвсгэрт байршихтай холбоотой хэд хэдэн тодорхой шаардлагууд туссан байдаг. Иймд тус Журам батлагдсанаас хойш олон нийт, аж ахуйн нэгжүүдийн зүгээс хүний эмзэг мэдээллийг гадаад улсын сервер ашиглан боловсруулж болох эсэх, эмзэг мэдээллийг гадаад улс руу дамжуулахад аливаа асуудал үүсэх эсэхтэй холбоотой түгээмэл асуултуудыг гаргаж тавих болсон.

Иймд та уг асуудлаар болон Хүний хувийн мэдээллийг хамгаалахтай холбоотой аливаа бусад асуудлаар зөвлөх үйлчилгээ хайж байвал бидэнтэй холбогдож уг чиглэлээр мэргэшсэн хуульчдаас зөвлөгөө аваарай.

Let's talk!

For a deeper discussion on the topic, please contact:

Серги Кобахидзе

Евроази хариуцсан Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
sergi.kobakhidze@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний ахлах менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Батзулын Амарбат

Хуулийн үйлчилгээний менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
amarbat.batzul@pwc.com

Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn



PwC Legal
A multidisciplinary law firm

www.pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН бэлтгэсэн болно. Энд дурдсан мэдээлэл нь зөвхөн ерөнхий мэдээлэл өгөх зорилготой бөгөөд дурдсан тухайн асуудал бүрээр олон талын цогц дүн шинжилгээг агуулаагүй болно. Аливаа үйлдэл (эс үйлдэхүй) хийхээс өмнө уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирох тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгад үндэслэн хийсэн үйлдэл, эс үйлдэхүйн хувьд бид аливаа хариуцлага хүлээхгүй болно.

© 2024 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү баримт бичигт дурдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ийг илэрхийлнэ.